



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2018 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 120 ГАГ-БНАТАГ-12018/0072 Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “2016, 2017 оны Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмийн зардлын төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авалтын байдал”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитаар хийсэн биет тооллогоор эмийн сангийн эм олгох хэсгээс 125,267 төгрөгийн үнэ бүхий 797 ширхэг эм, эмнэлгийн хэрэгсэл дутагдсан байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь “...төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг. Нэгдсэн эмнэлгийн эмийн сангийн эм олгох хэсгээс аудитын биет тооллогоор дутагдсан 125,267 /Нэг зуун хорин таван мянга хоёр зуун жаран долоон/ төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг эм найруулагч М.Сэргэлэнгээр төлүүлж, Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 10030000947 тоот дансанд төвлөрүүлэх.


Хоёр. Төлбөрийн актыг 2018 оны 10 дугаар сарын 20-ны дотор бүрэн барагдуулж, холбогдох санхүүгийн баримтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга

2518121

Н.Баттогтох, ерөнхий нягтлан бодогч Д.Сайнбаяр, эмийн нягтлан бодогч Д.Ганхүлэг нарт хариуцуулав.

## АКТЫГ


### ТОГТООСОН:

АУДИТОР  Б.АЗБАЯР  
АУДИТОР  Б.НАРАНГӨРЭЛ



6417143544  
БҮА0067 9007423

### ЗӨВШӨӨРСӨН:

БАЯНХОНГОР АЙМГИЙН НЭГДСЭН  
ЭМНЭЛГИЙН ДАРГА  
 Н.БАТТОГТОХ  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ  
 Д.САЙНБАЯР  
ЭМИЙН НЯГТЛАН БОДОГЧ  
 Д.ГАНХҮЛЭГ  
ЭМ ЗҮЙЧ  М.СЭРГЭЛЭН



1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын  
газрын 2018 оны 09 дугаар сарын  
14-ний өдрийн 200 тоот актын  
хавсралт

6417143544  
БНДА00067 9007423

дд	Эмийн нэр	Дутагдсан тоо хэмжээ	Үнийн дүн	Нийт дүн
1	Ампициллин 0.1сая	30	400	12000
2	Анальгин	6	720	4320
3	Нэг удаагийн бээлий	294	150,7	44307
4	Витамин К	26	350	9100
5	Лаферобион 1000000	2	3100	6200
6	Систем	153	255,1	39033
7	Шприц 0,5	98	105	10308
	Нийт дүн			<b>125267</b>



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2018 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 121 ГТГ-БНАТАГ-10018 /-08-ГА  
Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “2016, 2017 оны Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмийн зардлын төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авалтын байдал”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2017 оны 10 дугаар сарын 12-ноос 23-ний хооронд дотрын тасагт хэвтэн эмчлүүлсэн иргэний өөрөөс хэрэглэсэн эмийн үнийн эргэн олголтод “Мөнхийн тун” ХХК-ийн 10 дугаар сарын 25-ний өдрийн баримтаар 113,8 мянган төгрөгийг олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6-д заасан “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь “...төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг. Өөрөөс хэрэглэсэн эмийн үнэнд шаардлага хангахгүй баримтад үндэслэн олгосон 113,800 /Нэг зуун арван гурван мянга найман зуун/ төгрөгийг эмийн нягтлан

2518123

бодогч Д.Ганхүлэгээр төлүүлж, төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 10030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

Хоёр. Төлбөрийн актыг 2018 оны 10 дугаар сарын 20-ны дотор бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга Н.Баттогтох, ерөнхий нягтлан бодогч Д.Сайнбаяр нарт хариуцуулав.


### АКТЫГ

ТОГТООСОН:

АХЛАХ АУДИТОР  Б.ДОЛЖМАА



ЗӨВШӨӨРСӨН:

БАЯНХОНГОР АЙМГИЙН  
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГА  
 Н.БАТТОГТОХ  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ  
 Д.САЙНБАЯР  
ЭМИЙН НЯГТЛАН БОДОГЧ  
 Д.ГАНХҮЛЭГ



1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.